БиДиСЕК ҮЦК ХК

Андеррайтер, Брокер, Хөрөнгө оруулалтын зөвлөх

# ЖИЛИЙН ТАЙЛАН
# 2019

# АГУУЛГА

ТУЗ-ИЙН ДАРГЫН ИЛГЭЭЛТ

КОМПАНИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

*ТУЗ-ын дарга Б.Лхагвадорж*

# ТУЗ-ЫН ДАРГЫН ИЛГЭЭЛТ



Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажиллагсад та бүхэндээ Төлөөлөн Удирдах Зөвлөлийг төлөөлөн 2019 оны үйвл ажиллагааны үр дүнг танилцуулж байгаадаа баяртай байна.

Өнгөрөгч 2019 онд манай хамт олон үйл ажиллагаагаа өргөтгөн, үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлж, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхээр олон ажлыг зохион байгуулж, үр дүнд хүрсэн жил байлаа.

Бид өнгөрсөн онд харилцагчдын тоог 15%-аар нэмэгдүүлэн, нийт 280,000 гаруй харилцагчидтай болж, зах зээлд тэргүүлэх байр суурыа батжуулж чадлаа. Үүнд харилцагчийн данс нээх болон арилжааны захиалга авах үйлчилгээг online системээр хүргэх шинэ үйлчилгээг нэвтрүүлсэн нь ихээхэн нөлөө үзүүлсэн юм.

Даатгалын салбарын томоохон компаниудын нэг "Бодь даатгал"ХХК-ийн үнэт цаасыг нийтэд гарган IPO хийхээр андеррайтерын гэрээ байгуулан ажиллаж, эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийг авааД байна.


Энэ жил нийт экспортын хэмжээ нь 1 тэрбум доллар даваад байгаа "Эрдэнэс Таван Толгой"ХК-ийн хувьцааг Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэн нээлт хувьцаат компани болгох ажиллагаанд Тэрүүлэх андеррайтераар сонгогдон ажиллаж байгааг дуулгахад таатай байна. Энэхүү үйл ажиллагааг 2020 оны эхний хагаст багтаан хэрэгжүүлснээр хөрөнгийн зах зээлд томоохон түлхэц үзүүлж, иргэдийн гар эзэмшлийн хувьцааг арилжаалах бололцоо нээгдэх юм.

Гадаад зах зээл дэх үнэт цаасны арилжаанд дотоодын харилцагчдыг зуучлах үйл ажиллагааны хүрээнд бид олон улсын тэргүүлэгч онлайн брокер болох Саксо Групптэй хамтран ажилладаг бөгөөд 2019 онд манай зуучлалын гадаад арилжаа өмнөх оноос 20 дахин, харилцагчийн тоо 3 дахин өссөн амжилттай ажилласан байна.

2018 оноос эхлэн хэрэгжүүлсэн "shareholders activism" арга хэмжээний хүрээнд хувьцааны тодорхой багцыг нь эзэмшдэг 4 Хувьцаат компанитай илүү идэвхтэй хамтран ажилласнаар "Женко Тур Бюро"ХК-ны цэвэр ашиг түүхэн дээд хэмжээ болох 1,3 тэрбум төгрөгт хүрч, анх удаа 800 сая төгрөгийн ногдол ашиг тараах шийдвэр гаргаад байна.

Улсынхаа эдийн засаг, хөрөнгийн зах зээлд гарч буй өсөлт, өөрчлөлтүүдийг ашиглан, манай хамт олон өмнөх онуудад хийсэн ажил, хүрсэн амжилтдаа тулгуурлан, улам ихийг хийж бүтээхээр шамдан ажиллах болно. Ингээд манай компанийг сонгон үйлчлүүлдэг харилцагч, хөрөнгө оруулагчид болон бидэнд итгэл хүлээлгэсээр ирсэн хамтран ажилладаг байгуулагууддаа гүн талархал илэрхийлье. Харилцагч, хөрөнгө оруулагч та бидний хамтын ажиллагаа өргөжин тэлж, бизнес тань цэцэглэн хөгжинө гэдэгт итгэлтэй байна.

# БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ЫН ДАРГА



**Б.ЛХАГВАДОРЖ**
ТЭРГҮҮН ДЭД ЗАРИХАЛ

ЕРДИЙН ГИШҮҮД



**Д.ДАЯНБИЛГҮҮН**
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



**Н.БАТГЭРЭЛ**
ДЭД ЗАХИРАЛ, БИДИСЕК ҮЦК ХК



**JAMES PASSIN**
ПОРТФАЙЛ МЕНЕЖЕР

ХАРААТ БУС ГИШҮҮД



**Д.АМГАЛАНБАЯР**
ЗАХИРГААНЫ АЖИЛТАН, MSM LLC



**HITOSHI TANI**
ЕРӨНХИЙЛӨГЧ, EXE GROUP



**Б.ЭНХБАЯР**
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, EXE GROUP



**Б.АМАРСАНАА**
ЗАХИРАЛ, ХЭРЭЭЖИ ХХК



**ULUC BINGOL**
ДЭД ЗАХИРАЛ, ИМПЕРА КАПИТАЛ

ТУЗ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



**Б.ТЭМҮҮЛЭН**
МЕНЕЖЕР ИНСТИТУЦИОНАЛЬ ХАРИЛЦАГЧИЙН АЛБА, БИДИСЕК ҮЦК ХК

## ТУЗ-ЫН ДЭРГЭДЭХ ХОРООД

- Цалин Урамшууллын Хороо
- Аудитын Хороо
- Нэр Дэвшүүлэх Хороо

# ЭРХЭМ ЗОРИЛГО

## ЗОРИЛГО

Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартад нийцсэн санхүүгийн зах зээлд тэргүүлэгч байгууллага болох

## ЗОРИЛТУУД

### БОГИНО ХУГАЦААНД

Гадаад Харилцааг Өргөжүүлэх, үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, Компанийн боловсон хүчнийг чадваржуулах, ХОЗҮ-г өргөжүүлэх

### ДУНД ХУГАЦААНД

Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, Олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах, МХЗЗ-д оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх.

### УРТ ХУГАЦААНД

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа, Үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох

# ТҮҮХЭН ЗАМНАЛ



**1991**

Баян Дөхөм брокерийн пүүс Зуунмод хотод байгуулагдсан.



**1997**

Улаанбаатар хотод салбар байгуулагсан.



**1998**

Компанийн төв оффисыг Улаанбаатар хотод шилжүүлэн “БиДиСЕК” ХХК нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж шинэ менежементийн системтэйгээр ажиллаж эхэлсэн.




**2012**

Монголын хөрөнгийн биржийн арилжааны 91%-ийг дангаар гүйцэтгэж түүхэн амжилт тогтоов.



**2017**

Монгол улсын ХЗЗ-д хийгдсэн хамгийн том M&A болох АПУ ХК болон “Эвэргрийн Инвестмэнт” ХХК-ийн нэгдлийг амжилттай гүйцэтгэсэн.



**2018**

Монгол улсын анхны давхар бүртгэлт(cross-list) -ийг амжилттай гүйцэтгэсэн.



**2000**

Засгийн газрын бондын томоохон дилер болсон.




**2005**

СЗХ-оос андеррайнтерийн үйлчилгээ үзүүлэх эрх авч анхны IPO амжилттай хийсэн.



**2006**

Олон нийтэд нээлттэй цорын ганц ҮЦК болсон.

ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ
ERDENES-TT

**2019**

Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн дотоодын бүртгэл тэргүүлэгч андеррайтераар сонгогдов.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ
ERDENES-TT

Нийт арилжааны хэмжээ 1,000,000 ам доллар давав.

Stocks to Watch - 2019 нийтлэв.

Дотоодын бүртгэлд тэргүүлэх андеррайтераар сонгогдов.

SAXO BANK

Нийт харилцагчийн тоо 280,000 хүрэв.


BDSec JSC
TOP 10 COMPANIES ON MONGOLIAN STOCK EXCHANGE
August 2019
Stocks to Watch - 2019
Industry Coverage


Долоо хоногийн зах зээлийн тойм мэдээг санхүүгийн үзүүлэлт, ханшийн өөрчлөлт зэргийг нэгтгэн харилцагчдад хүргэдэг болов.

# ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид өөрсдийн харилцагч, хөрөнгө оруулагч нартаа Монголын Хөрөнгийн Зах Зээл дээрээс хувьцаа, бонд худалдах, худалдан авах арилжаанд зуучилж, мэдээ мэдээлэл, зөвлөгөөг хүргэхээс гадна гадаадын хөрөнгийн биржээс үнэт цаас худалдах, худалдан авахад зуучилж цогц үйлчилгээг хүргэж байна.


## ХАРИЛЦАГЧИЙН ТОО

"БиДиСЕК ҮЦК" ХК нь 2019 онд нийт 27,360 данс шинээр нээснээр нийт харилцагчдын тоо 280,000-д хүрсэн. Монгол улсын хөрөнгийн зах зээл дээрх нийт харилцагчдын 15% нь манай компаниар үйлчлүүлж байна.




## ХУВЬЦААНЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖААНЫ ДҮН

"БиДиСЕК ҮЦК" ХК нь сүүлийн 8 жилийн байдлаар зах зээл дэх өдөр тутам хийгддэг хоёрдогч зах зээлийн арилжааны 24.5%-ийг дангаар гүйцэтгэсэн.



# БРОКЕРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

## ОНЛАЙН БРОКЕР ҮЙЛЧИЛГЭЭ




Харилцагчид вэб хөтчөөр гар утас, компьютер ашиглан ХААНААС Ч, ХЭЗЭЭ Ч Монголын хөрөнгийн биржийн арилжаанд оролцох захиалгаа илгээх, даунсны үлдэгдэл, гүйлгээ, мэдээллээ харах боломжтой үйлчилгээ юм. Тус үйлчилгээ нь хэрэглэгчдийн

## ОНЛАЙН ДАНС НЭЭХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бид 2019 онд онлайнаар данс нээх үйлчилгээг нэвтрүүлснээр харилцагч заавал өөрийн биеэр ирэлгүйгээр гар утас, компьютер ашиглан хаанаас ч дансаа нээлгэх боломжтой

## АРИЛЖААНЫ ТАНХИМААР ҮЙЛЧЛЭХ


Хөрөнгө оруулагч, харилцагчиддаа арилжаанд шууд оролцох боломжийг бий болгон, орчинг бүрдүүлэн ажилладаг. Ингэснээр арилжаанд идэвхитэй оролцдог харилцагчид онлайнаар захиалгаа илгээхээс гадна Хөрөнгийн Биржийн арилжааны цагаар арилжааны танхимд ирж үйлчлүүлж байна.

## МЭДЭЭЛЭЛ, СУДАЛГАА

Харилцагч нартаа арилжааны өдөр тутмын болон 7 хоногийн тойм мэдээг хүргэхээс гадна хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниуд, шинэ IPO-ийн үнэлгээ зэрэг судалгаануудыг

## САЛБАРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Компани нь Санхүүгийн зохицуулах хороноос салбарын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй Орхон аймаг, Дархан-Уул аймаг, Төв аймаг, Дорноговь аймаг, Улаанбаатар хотын төв салбаруудаараа дамжуулан тогтмол үйл ажиллагаагаа харилцагч, хөрөнгө оруулагчдадаа хүргэн ажилласан.



# ҮЙЛ АЖИЛЛАГАА

## ИНСТИТУЦИОНАЛЬ ХАРИЛЦАГЧИЙН АЛБА

Институциональ харилцагчийн алба нь томоохон байгууллага болон гадаад харилцагчидтай харилцдад брокерийн үйлчилгээ үзүүлэх мөн дотоодын харилцагчдыг

### ГАДААД ХАРИЛЦАГЧ




Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д бүртгэлтэй нийт гадаадын хөрөнгө оруулагчдын 45% нь манай компанийн харилцагч юм.

### СУДАЛГАА, АНАЛИЗ

2019 онд Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй ТОП – 15 ХК дээр судалгаа хийн “Stocks to Watch – 2019”, мөн долоо хоног болгоны шинжилгээг харилцагчиддаа хүргэсэн.



### ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДИЙН УУЛЗАЛТ

Бид өөрийн харилцагчид, Монголд хөрөнгө оруулалт хийхээр сонирхон судалж байгаа дотоод, гадаадын томоохон хөрөнгө оруулагчдыг хувьцаат компаниуд, төрийн байгууллага, Засгийн газрын нэгжүүдтэй хийх уулзалтыг тогтмол зохион байгуулдаг. 2019 онд нийт 40 гаруй уулзалтыг зохион байгуулсан байна.

## ГАДААД АРИЛЖАА ЗУУЧЛАЛ

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2017 оны 5-р сарын 11-ний өдөр “Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа”-ны зөвшөөрөл авснаар дотоодын харилцагчиддаа олон улсын зах зээл дэх үнэт цаасны арилжаанд оролцох боломжоор бүрдүүлээд байна. Компани нь тус үйлчилгээний хүрээнд олон улсын тэргүүлэгч онлайн брокер Саксо Групптэй хамтран ажиллаж байна.

Saxo Bank нь 1992 онд байгуулагдаж, хамгийн анхны онлайн арилжааны платформ зохион бүтээж хувиараа хөрөнгө оруулагчдад мэргэжлийн хөрөнгө оруулагч, хөрөнгө оруулалтын сангуудтай адилхан үйлчилгээг нэвтрүүлсэн, Дани улсад төвтэй, 10 гаруй улсад салбартай бөгөөд дэлхийн 150 улсад хүрч ажиллаж байна.

## МАНАЙ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭЛ:

Бид харилцагдийн **1,000,000 $**-ийн гүйлгээг Saxo Bank-тай хамтран хийж гүйцэтгэлээ.




*“ГАДААД АРИЛЖААНД ОРОЛЦОХ НЬ” арга хэмжээг амжилттай зохион байгуулсан.*

# АНДЕРРАЙТЕРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

БиДиСЕК ҮЦК ХК нь Монгол улсын эдийн засгийн хөгжил үйлдвэржилтэд хувь нэмэр оруулахуйц үндэсний үйлдвэр, компаниудад хөрөнгө оруулалт татахад нь бүхий л талаар дэмжин ажиллаж, Монголын хөрөнгийн зах зээл дээр шинээр гаргасан хувьцаа болон бондын андеррайтераар ажилладаг.

Бид мөн жижиг дунд үйлдвэрлэл аж ахуйн нэгжүүд, старт-ап компаниудтай хаалттай болон нээлттэй бондоорх хөрөнгө оруулалт хийх, хувьцаа эзэмших зэргээр хамтран ажиллаж байна.

2005 он

## АНХНЫ IPO / 0.8₮ тэрбум /

Монгол Шилтгээн ХК аялал жуулчлалын цогцолборыг байгуулахад шаардлагатай санхүүжилтыг МХБ дээр хувьцаа гарган арилжаалах замаар татан төвлөрүүлэхэд андеррайтераар ажилласан.

2006 он

## ХАМГИЙН ТОМ ХӨШӨӨТ ЦОГЦОЛБОР, IPO / 8.3₮ тэрбум /

GENCO TOUR BUREAU JSC

Женко Тур Бюро ХК нь 2006 онд МХБ дээр нийтэд хувьцаагаа санал болгож нийт 8.26 тэрбум төгрөгийн санхүүжилт босгосон. Энэхүү санхүүжилтээр Чингис хааны хөшөөт цогцолборын бүтээн байгуулалтыг эхлүүлж 2008 онд ашиглалтад оруулсан.

2018 он

## ХАМГИЙН ТОМ M&A НЭГДЭЛ / 338₮ тэрбум /

APU COMPANY
Absolute. Pure. Unique.


Монголын шингэн хүнсний салбарын томоохон үйлдвэрлэгч АПУ ХК нь Эвергрийн инвестмент ХХК-тай нэгдсэн нь Монголын хөрөнгийн зах зээл дээр хамгийн том дүнтэй нэгдэл болсон. Үүний дараа АПУ ХК-ийн хувьцааны үнэ огцом өсч, зах зээлийн үнэлгээ нь 1 их наяд гарсан анхны хувьцаат компани болсон.

2018 он

## АНХНЫ ДАВХАР БҮРТГЭЛ / 2.49₮ тэрбум /

Erdene Resource Development

Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Эрдэнэ Ресурс Девелопмент компанийн хувьцааг Монголын хөрөнгийн биржид давхар бүртгэх, олон нийтэд санал болгон арилжаалах ажиллагааг амжилттай гүйцэтгэсэн.



# ГҮЙЦЭТГЭСЭН АЖИЛ

## ЭРДЭНЭС ТАВАНТОЛГОЙ ХК

БиДиСЕК ҮЦК ХК нь Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн МХБ, СЗХ-д нээлттэй хувьцаат компаниар бүртгэгдэх ажиллагаанд тэргүүлэх андеррайтераар ажиллаж байна.

Компани Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд нээлттэй хувьцаат компаниар бүртгүүлэх ажиллагаа амжилттай хийгдсэнээр Монгол Улсын Их Хурлын 2011 оны 57 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн Газрын 2012 оны 181 дүгээр тогтоолууд хэрэгжих суурь нөхцөл бүрдэнэ. Цаашид эдгээр тогтоол бүрэн хэрэгжсэнээр компанийн хувьцаа эзэмшигчид болох иргэд, аж ахуй нэгж байгууллагууд Монгол улсын хөрөнгийн зах зээлээр дамжуулан өөрийн эзэмшлийн "Эрдэнэс таван толгой" Хаалттай ХК-ийн хувьцааг арилжаалах, хувьцаанаас өгөөж хүртэх боломж нээгдэнэ.

## БОДЬ ДААТГАЛ IPO

БиДиСЕК ҮЦК ХК нь Бодь даатгалын 2019 онд даатгалын салбарын томоохон компаниудын нэг Бодь даатгал ХХК-ийн үнэт цаасыг нийтэд гарган IPO хийхээр андеррайтераар ажиллаж байгаа ба холбогдох байгууллагуудын зөвшөөрлийг авааД байна.

## АЧИТ ЗЭС ХК


Ачит Ихт ХХК нь нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол улсад анх удаа давуу эрхийн хувьцааг хаалттай хүрээнд буюу Ачит Ихт ХХК болон Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн ажилчдад өөрийн 100%-ийн охин компани болох Ачит Зэс Хаалттай ХК-иар дамжуулан эзэмшүүлсэн.

БиДиСЕК ҮЦК ХК нь хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээний хүрээнд Ачит Зэс Хаалттай ХК-ийн давуу эрхийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг зохион байгуулан ажиллаж байна.

# ҮЙЛ АЖИЛЛАГАА

## НИЙТ АРИЛЖААНЫ ДҮН

/тербум төгрөг/




## 2019 ОНЫ АРИЛЖААНЫ ДҮН

/сая төгрөг/




**Σ 280,000**

НИЙТ ХАРИЛЦАГЧ

**+ 27,360**

НЭЭСЭН ДАНС

# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

## НИЙТ ХӨРӨНГӨ





## ЭХ ҮҮСВЭРИЙН БҮТЭЦ




# САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

## ОРЛОГО


/тербум төгрөг/




## АШИГТ АЖИЛЛАГААНЫ ШИНЖИЛГЭЭ




НИЙТ ХӨРӨНГИЙН ӨГӨӨЖ /ROA/




ХУВЬЦААТ КАПИТАЛЫН ӨГӨӨЖ /ROE/

# АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ

ДАЛАЙВАН АУДИТ
Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

**ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН**

**“БИДИСЕК ҮЦК” ХК-ИЙН**
**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД**

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Бид 2019 оны 12 дугаар сарын 31-ээрх нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх нэгтгэсэн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “БиДиСек ҮЦК” ХК болон түүний охин компани “БиДиСиЭйПи” ХХК, “Их Чингис Хааны хөмрөг” ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан асуудлын санхүүгийн тайланд үзүүлж болзошгүй нөлөөллийг эс тооцвол “БиДиСек ҮЦК” ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дууссгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн Монгол улсын Сангийн яам, Санхүүгийн Зохицуулах Хорооноос батлан гаргасан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

**Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл**

Худалдааны болон худалдааны бус авлагын дүнд багтсан эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй 484,982.4 мянган төгрөгийн авлагын үнэ цэнийн бууралтыг тооцож төлөгдөхөөр хүлээгдэж байгаа цэвэр дүнгээр тайлагнаагүй. Аудиторууд аудитын нэмэлт горим гүйцэтгэж тус авлагуудын бодит үнэ цэнийг хэмжиж залруулга хийх боломжгүй байсан.

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн бүрэлдэхүүнд “БиДиСиЭйПи” ХХК-ийн эзэмшиж буй “БиДиСек ҮЦК” ХК-д оруулсан нийт 350,708.3 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгө оруулалт бүртгэсэн. Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ уг хөрөнгө оруулалтын хувьд нэгтгэлийн горимыг баримтлаагүйгээс нэгтгэсэн санхүүгийн тайлангийн Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн болон эздийн өмчийн үлдэгдэл тус дүнгээр илүү илэрхийлэгдэхэд нөлөөлсөн.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын хязгаарлалттай дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж бид үзэж байна.

bakertilly
INTERNATIONAL

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН
**(үргэлжлэл)**

**Аудитын гол асуудлууд**

Бидний гаргасан тайланд нөлөөлөхүйц хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна..

**Бусад мэдээлэл**

Компани нь аудитлагдсан нэгтгэсэн санхүүгийн тайланг хүлээн авч хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлсний дараа жилийн үйл ажиллагааны тайланг бэлтгэдэг. Аудитлагдсан нэгтгэсэн тайланг хүлээн авсны дараа жилийн тайлангаа хүргүүлэх талаар удирдлага мэдэгдсэн тул аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

**Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-уудын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй нэгтгэсэн санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийг хэрэглэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Компанийн засаглах удирдлага нь нэгтгэсэн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

**Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол нэгтгэсэн санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид дараах ажлуудыг хийсэн:

- Нэгтгэсэн санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаас шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.

- Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд компанийн дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- Хэрэв компанийн тасралтгүй байх чадавхад материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт анхаарлаа хандуулах болно. Энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд компанийн тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.
- Нэгтгэсэн санхүүгийн тайлантай холбоотой дүгнэлт гаргахын тулд бид компаниудад хамаарах аж ахуйн нэгж болон бизнесийн үйл ажиллагааны санхүүгийн мэдээлэлтэй холбоотой хангалттай хэмжээний тохиромжтой аудитын баримт нотолгоо олж авсан.

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээлэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

**Тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу “БиДиСек ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хэрэгцээнд зориулан бэлтгэсэн бөгөөд бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч этгээдийн өмнө ямар нэг хариуцлага хүлээхгүй болно.

**ДАЛАЙВАН АУДИТ ХХК**
**УЛААНБААТАР ХОТ**
**МОНГОЛ УЛС**

**2020 ОНЫ 02 ДУГААР**
**САРЫН 28 -НЫ ӨДӨР**

# АУДИТЫН ТАЙЛАН, ДҮГНЭЛТ



## НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31

| Үзүүлэлт | Тодруулга | 2019.12.31 мянган төгрөг | 2018.12.31 мянган төгрөг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | | |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө | 5.1 | 51,974.9 | 63,771.2 |
| Худалдааны ба бусад авлага | 5.5 | 1,973,921.4 | 1,733,787.6 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 5.2-5.3 | 14,794,484.0 | 14,181,486.2 |
| **Эргэлтийн хөрөнгийн дүн** | | **16,820,380.3** | **15,979,045.0** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | | |
| Үндсэн хөрөнгө – цэвэр | 5.6 | 4,665,347.4 | 4,801,467.3 |
| Биет бус хөрөнгө - цэвэр | 5.7 | 16,259.5 | 18,106.9 |
| Урт хугацаат хөрөнгө оруулалт | 5.4 | 1,000.0 | 1,000.0 |
| Урт хугацаат авлага | 5.8 | 34,195.1 | 53,284.0 |
| **Эргэлтийн бус хөрөнгийн дүн** | | **4,716,802.0** | **4,873,858.1** |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **21,537,182.3** | **20,852,903.0** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | | |
| Худалдааны ба бусад өглөг | 5.9 | 235,714.2 | 331,154.0 |
| Банкны богино хугацаат зээл | 5.10 | 173,437.3 | 861,312.8 |
| Орлогын албан татварын өглөг | 5.12 | 7,373.6 | 169,180.7 |
| Бусад татвар, шимтгэлийн өглөг | 5.12 | 61,127.7 | 83,553.6 |
| Хүүний өглөг | 5.11 | 19,140.3 | 17,485.0 |
| Урьдчилж орсон орлого | 5.13 | 242.2 | 242.2 |
| **Богино хугацаат өр төлбөрийн дүн** | | **497,035.3** | **1,462,928.2** |
| **Урт хугацаат өр төлбөр** | | | |
| Банкны зээл урт хугацаат | 5.10 | 3,828,062.0 | 2,197,824.6 |
| **Урт хугацаат өр төлбөрийн дүн** | | **3,828,062.0** | **2,197,824.6** |
| **Нийт өр төлбөр** | | **4,325,097.3** | **3,660,752.8** |
| **ӨМЧ** | | | |
| Энгийн хувьцаа | 5.14 | 1,369,488,3 | 1,369,488,3 |
| Нэмж төлөгдсөн капитал | 5.14 | 7,957,309.3 | 7,957,309.3 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 5.14 | 3,824,524.4 | 3,824,524.4 |
| Хуримтлагдсан ашиг | 5.14 | 4,060,763.0 | 4,040,828.3 |
| **Нийт өмч** | | **17,212,085.0** | **17,192,150.3** |
| **НИЙТ ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | **21,537,182.3** | **20,852,903.1** |

## НЭГТГЭСЭН ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31

| Үзүүлэлт | Тодруулга | 2019.12.31 мянган төгрөг | 2018.12.31 мянган төгрөг |
|---|---|---|---|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 5.15 | 1,395,207.4 | 4,868,545.2 |
| Бусад үйл ажиллагааны орлого | 5.16 | 133,339.1 | 132,217.9 |
| Үйл ажиллагааны зардал | 5.17 | 1,849,572.2 | (3,563,652.6) |
| **Үйл ажиллагааны ашиг/алдагдал** | | **(321,025.7)** | **1,437,110.5** |
| Санхүүгийн орлого | 5.18 | 1,086,144.5 | 481,058.9 |
| Санхүүгийн зардал | 5.18 | (655,606.1) | (438,991.8) |
| Өмчөөр тайлагнагдах хараат компанийн цэвэр ашгийн ногдох хувь | | - | 116,445.9 |
| Үйл ажиллагааны бус орлого/(зардал) | 5.19 | (81,520.3) | 95,944.1 |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг/(алдагдал)** | | **27,992.4** | **1,691,567.6** |
| Орлогын татварын зардал | 5.20 | 8,057.7 | 180,780.3 |
| **Тайлант жилийн цэвэр ашиг/(алдагдал)** | | **19,934.7** | **1,510,787.3** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого:** | | | |
| **Ашиг, алдагдлаар дахин ангилагдахгүй зүйлс:** | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | | - |
| **Ашиг, алдагдлаар дахин ангилагдах зүйлс:** | | | |
| Богино хугацаат хөрөнгө оруулалтын хэрэгжээгүй олз/(гарз) | | | - |
| Хэрэгжээгүй олзод ногдох хойшлогдсон татвар | | | - |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | | | - |
| **Нийт дэлгэрэнгүй орлого/(зардал)** | | **19,934.7** | **1,510,787.3** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг/(алдагдал)** | | | |
| Суурь (төгрөг) | | 1.5 | 110.3 |

...IVAN AUDIT
...(CPA)...
& APPR...

## НЭГТГЭСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31

| Үзүүлэлт | Хувьцаат капитал | Нэмж төлөгдсөн капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан ашиг | Нийт өмч |
|---|---|---|---|---|---|
| | мянган төгрөг | мянган төгрөг | мянган төгрөг | мянган төгрөг | мянган төгрөг |
| **2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,369,488.3** | **7,957,309.3** | **3,824,524.4** | **2,533,245.7** | **15,684,567.7** |
| Гаргасан хувьцаа | | | | | |
| Халаасны хувьцаа | | | | | |
| Нэмж төлөгдсөн капитал | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз/(гарз) | | | | | |
| Хуваарилсан ногдол ашиг | | | | | |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | | | 1,510,787.3 | **1,510,787.3** |
| Залруулга | | | | (3,204.7) | **(3,204.7)** |
| **2018 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,369,488.3** | **7,957,309.3** | **3,824,524.4** | **4,040,828.3** | **17,192,150.3** |
| Гаргасан хувьцаа | | | | | |
| Халаасны хувьцаа | | | | | |
| Нэмж төлөгдсөн капитал | | | | | |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз/(гарз) | | | | | |
| Хуваарилсан ногдол ашиг | | | | | |
| Тайлант жилийн цэвэр ашиг | | | | 19,934.7 | **19,934.7** |
| Залруулга | | | | | |
| **2019 оны 12 сарын 31-ний үлдэгдэл** | **1,369,488.3** | **7,957,309.3** | **3,824,524.4** | **4,060,763.0** | ***17,212,085.0*** |

# НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2019 оны 12 дугаар сарын 31

| Үзүүлэлт | 2019.12.31 Мянган төгрөг | 2018.12.31 Мянган төгрөг |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| *Мөнгөн орлогын дүн* | ***2,750,673.2*** | ***8,753,643.0*** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 2,713,952.1 | 8,752,694.4 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | | |
| Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө | | |
| Бусад орлого | 36,721.1 | 948.5 |
| *Мөнгөн зарлагын дүн* | ***3,562,661.8*** | ***14,052,493.8*** |
| Санхүүгийн хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө | 1,324,509.6 | 9,549,946.4 |
| Ажиллагсдад төлсөн мөнгө | 548,554.4 | 557,680.2 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 143,460.1 | 136,073.1 |
| Түүхий эд, материал худалдан авахад төлсөн | 38,640.7 | 61,088.2 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 86,436.2 | 25,573.2 |
| Түлш шатахуун, сэлбэг хэрэгсэлд төлсөн | 17,989.4 | 21,131.1 |
| Хүүний төлбөрт төлсөн | 573,512.8 | 261,610.6 |
| Татварын байгууллагад төлсөн | 210,520.5 | 203,366.0 |
| Шимтгэл хураамжид төлсөн | 0 | 99,184.6 |
| Даатгалын төлбөрт төлсөн | 2,147.7 | 2,707.8 |
| Бусад мөнгөн зарлага | 613,438.8 | 3,134,132.6 |
| ***Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **(811,988.7)** | **(5,298,850.8)** |
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| *Мөнгөн орлогын дүн* | ***55,163.6*** | ***1,911,557.9*** |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | 0 | 501,600.0 |
| Биет бус хөрөнгө борлуулсны орлого | | |
| Хүүний орлогоос хүлээн авсан | 35,903.6 | 271,203.0 |
| Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого | 19,260.0 | |
| Бусдад олгосон зээлийн эргэн төлөлт | | 1,138,754.9 |
| *Мөнгөн зарлагын дүн* | ***150,651.0*** | ***1,221,507.2*** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 13,476.7 | 24,336.2 |
| Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 137,174.3 | |
| Бусдад олгосон зээл | | 1,197,171.0 |
| ***Хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээ*** | **(95,487.4)** | **690,050.7** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| *Мөнгөн орлогын дүн* | ***6,820,769.8*** | ***7,668,520.5*** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 6,720,769.8 | 7,654,684.5 |
| Бусад мөнгөн орлого | 100,000.0 | 13,836.0 |
| *Мөнгөн зарлагын дүн* | ***5,925,305.0*** | ***5,011,769.6*** |
| Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 5,925,305.0 | 5,011,769.6 |
| Төлсөн ногдол ашиг | | |
| ***Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээ*** | ***895,464.8*** | ***2,656,750.9*** |
| **Валютын ханшийн зөрүү** | *175.0* | *590.1* |
| **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(11,836.3)** | **(1,951,459.1)** |
| ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл*** | ***63,811.2*** | ***2,015,230.3*** |
| ***Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл*** | ***51,974.9*** | ***63,771.2*** |

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК ҮЦК” ХК.

Утас: 7555 1919
И-Мэйл: info@bdsec.mn